



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ  
ДАРГА Н.НАНЗАДДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2015.03.02 № 8/22

Г Албан шаардлага өгөх тухай

Төрийн өмчийн хорооны 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас Чингэлтэй дүүргийн шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 101 тоот шийтгэх тогтоолын дагуу ТӨХ-ны 17000055548 тоот данс дахь өмч хувьчлалын орлого болох 3,540,150,000 төгрөгийг 2009 оны 02 дугаар сарын 4-ний өдөр данснаас мөнгө шилжүүлэх тухай мэдэгдлийн дагуу Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Хадгаламж банк дахь 1700062781 тоот дансанд татан авсан.

Шийтгэх тогтоолын 13 дугаар зүйлд “Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар шүүгдэгч Ц.Чимэдцэрэгнээс 14,200,000,000 төгрөгийг гаргуулж хохирогч Хадгаламж банкинд 700,000,000 төгрөг, Төрийн өмчийн хороонд 13,500,000,000 төгрөгийг тус тус олгосугай”, 14 дүгээр зүйлд “Иргэний хуулийн 497, 498, 510 дугаар зүйл зааснаар иргэний хариуцагч Төрийн өмчийн хорооноос 13,500,000,000 төгрөгийг гаргуулж хадгаламж банкинд олгосугай” гэсэн байна.

Мөн Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2011 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 112 тоот шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дууссан тухай тогтоолоор Төрийн өмчийн хороог төлбөрөө бүрэн төлж барагдуулсан тул гүйцэтгэлийн ажиллагааг дуусгасан байна. Харин иргэн Ц.Чимэдцэрэнгээр төлж барагдуулах төлбөрийн гүйцэтгэл ямар шатанд явж байгаа, хэрхэн барагдаж байгаа талаар Төрийн өмчийн хороо Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас тодруулан холбогдох арга хэмжээ авсан ажлын биелэлт байхгүй, өр авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах”, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

“Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

Чингэлтэй дүүргийн шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 101 тоот шийтгэх тогтоолын 13 дугаарын зүйлийн гүйцэтгэлийн ажиллагааны явцыг Нийслэлийн шийдвэр

гүйцэтгэх албанаас тодруулан холбогдох арга хэмжээ авч ажиллаж, өр авлагыг тооцоо нийлж баталгаажуулах.

Биелэлтийг 2015 оны 09 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Н.Нанзаддож, ерөнхий нягтлан бодогч Ш.Оюунтөгс нарт хариуцуулав.

АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

